

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 11 дүгээр сарын 28

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Дөрвөн улирлын аялал жуулчлал							
1.1. “Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох чиглэлээр:							
1	Арга хэмжээ-1.1.1 Жуулчдад зориулсан аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг зохион байгуулах	Нийслэлийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээ, оролцсон жуулчдын тоо	12 60,000	10 70,000	Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран 17 арга хэмжээг зохион байгуулж, гадаад, дотоодын нийт 288,836 хүн үзэж сонирхов. Үүнд: ✓ “Улаанбаатар өвлийн наадам” ✓ “Улаанбаатарын өвлийн явган алхалтын фестиваль” ✓ “Мөсөн замын авто машины уралдаан” ✓ “Монгол үндэстэн угсаатан дээлтэй жагсаал” ✓ “Бүргэдийн баяр” ✓ “Нарны баяр” ✓ "Нийслэлийн аварга шалгаруулах нээлттэй Монгол адуучин" тэмцээн, ✓ “Юби фүүд фестиваль-Үзбек улсын хоолны өдөрлөг” ✓ Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн "Magic dream" парад ✓ "Талын салхи" олон улсын мото фестиваль,	100

						✓ "Бурхан багшийн дүйчин өдөр" ✓ "Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр - Хүрээ цам даншиг наадам" ✓ "Плэйтийм" олон улсын хөгжмийн наадам ✓ "Дээлтэй Монгол" наадам, ✓ "Бэсрэг даншиг наадам" ✓ "Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль" ✓ "Хийморь" олон улсын морьт харвааны тэмцээн	
2	Арга хэмжээ-1.1.2 Улаанбаатар хотын аяллын "Сити тур" төслийг үргэлжлүүлэх	Нийслэлийн төсөв	Хотын аялалд хамрагдсан хүний тоо	7,380	7,500	Улаанбаатар хотын түүх, соёл, байгалийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлэх, гадаад дотоод жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор "Сити тур" төслийг хэрэгжүүлэн 23 удаагийн аяллаар нийт гадаад, дотоодын 7200 хүнийг хотын аялалд хамрууллаа.	96
3	Арга хэмжээ-1.1.3 Жуулчдын зорин очих аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх	Нийслэлийн төсөв	Шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн ий тоо	2	2	Улаанбаатар хот болон хот орчимд эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, жуулчдын зорин очих газар болон маршрутын тоог нэмэгдүүлэх зорилгоор "Эко Улаанбаатар 360 хөтөч" гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх ажлын хүрээнд ногоон бүсэд 11 төрлийн аяллын бүтээгдэхүүний төрлүүдийг бий болгож, 20 аяллын зам маршрутыг шинээр тогтоож, Богд уул, Зүрх уул, Чингэлтэй хайрхан, Тэрэлжийн зам харгуйг тэмдэгжүүлэх ажил хийгдэж байна.	100
4	Арга хэмжээ-1.1.4 Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх	Нийслэлийн төсөв	Үйлчилгээ үзүүлсэн хүний тоо	16,180	18,000	Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төв шуудан, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах "Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв", болон "Тэрэлж Монгол олле", "Хонхор тосгон Монгол олле", "Сөүлийн гудамж Монгол олле" зэрэг нийт 7 байршилд тогтмол болон улирлын чанартай ажиллуулж 17,208 хүнд, зохион байгуулсан арга хэмжээнүүдийн үеэр жуулчны мэдээлэл сурталчилгааны цэгийг ажиллуулж 6000 хүнд буюу нийт 23,208 гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.	100

5	Арга хэмжээ-1.1.5 Жуулчдыг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилготой “Оюутан цагдаа” хөтөлбөрийг үргэлжлүүлэх	Нийслэлийн төсөв ГХУСАЗНСЗ	Үйлчилгээ үзүүлсэн гадаад жуулчдын тоо	17,255	18,000	Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэднийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран “Оюутан цагдаа-2025 арга хэмжээг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хэрэгжүүлээ. Жуулчид ихээр зорчдог гудамж талбай, олон нийтийн газруудад 62 оюутныг өдөр бүр ээлжээр 10:00-13:00, 13:00-17:00 цагийн хооронд эргүүлийн 32 чиглэлд ажиллуулж аюулгүй ажиллагааны зааварчилгаа, зөвлөмжийг өгч, ажлын үр дүн, сахилга ёс зүйд тогтмол хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажиллаж, оюутан цагдаа нараас ажиллах хугацаандаа Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт гэмт хэргийн 4, зөрчлийн шинжтэй 18 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 11,860 иргэнд туслалцаа үзүүлэн, гадаадын 6,380 иргэнд хэлмэрчилэн гадаад, дотоодын нийт 18,240 хүнд үйлчилгээ үзүүлж, төрлийн 5,800 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийн үеэр 380 хүүхдэд эцэг эхийн утасны дугаар бүхий бугуйвч зүүж, эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 93 бага насны хүүхдийг ар гэрт нь хүлээлгэн өгсөн.	100
6	Арга хэмжээ-1.1.6 Аялал жуулчлалын байршуулах үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд стандартын үзлэг зохион байгуулах	Нийслэлийн төсөв	Байгууллагын тоо	105	600	Улаанбаатар хотод зочин байршуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, дэн буудал, жуулчны бааз, амралтын газруудад нэгдсэн үзлэг шалгалтыг 2025 оны III улиралд зохион байгуулахаар удирдамж боловсруулан төсвийн тооцоолол гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар албан даалгаврын хүрээнд үзлэг шалгалтын төсөв гаргах боломжгүй тухай чиглэл өгөгдсөн тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно.	30

7	Арга хэмжээ-1.1.7 Үндэсний болон хотын стандартуудыг иргэд, хуулийн этгээд, олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	4	Үндэсний болон хотын стандартуудыг сурталчлах чиглэлээр 4 арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: 1.Зочид буудалд ерөнхий шаардлага (MNS 4588:2008), Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага (MNS 6043:2019), Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага (MNS 5738:2007) үндэсний стандарт болон “Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага UCS1203:2022”, “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” UCS1401B:2022”, “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” UCS1706A:2022” хотын стандартуудыг “Улаанбаатар хотын амралтын газар, жуулчны баазуудын нэгдсэн мэдээ, мэдээлэл” цахим хуудаст байршуулж 5,000 гаруй хэрэглэгчдэд сурталчилсан. 2. Улаанбаатар зочид буудлын их танхимд 2025 оны 05 сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатар травэл экспо 2025” олон улсын аялал аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг ажиллуулж үндэсний болон хотын стандартуудын талаар 550 хүнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн. 3. "Мишээл Экспо" олон улсын үзэсгэлэн худалдааны төвд 2025 оны 10 дугаар сарын 24, 25, 26-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “ITM-МОНГОЛИА 2025” олон улсын аялал аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр үндэсний болон хотын стандартуудын талаар 850 хүнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн. 4. "Аялал жуулчлалын байршуулах үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөх, үндэсний болон хотын стандартуудын хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах зорилгоор холбогдох байгууллагуудтай хамтран 4 удаагийн үзлэг, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, стандартуудын хэрэгжилтийг	100
---	---	---	---	---	---	--	-----

						хангуулах, мэргэжлийн зөвлөн туслах үйл ажиллагааг үзүүлсэн.	
8	Арга хэмжээ-1.1.8 Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр дотоодын болон олон улсын туршлагыг судлах, экспертийн төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулах	Нийслэлийн төсөв	Зохион байгуулсан сургалтын тоо	8	8	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор холбогдох сургалтуудыг зохион байгуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны “Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай” 03 дугаар албан даалгаврын хүрээнд сургалтын үйл ажиллагааны төсөв гаргах боломжгүй тухай чиглэл өгөгдсөн тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно.	30
9	Арга хэмжээ-1.1.9 "Нэг жуулчин-нэг мод" жуулчны төгөл байгуулах төслийг үргэлжлүүлэх	Нийслэлийн төсөв	Тарьсан модны тоо	305	300	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монголын Аялал жуулчлалын холбоо “Цолмон трэйвел” ХХК-тай хамтран Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Жуулчин төгөл” байгуулах ажлыг 2022 онд эхлүүлж төслийн талбайд 27 төрлийн 1116 мод, бут сөөг тарьж суулгасан. Монголын Аялал жуулчлалын холбооны гишүүн 30 гаруй байгууллагатай хамтран 2025 оны 10 дугаар сарын 04-ний өдөр мод тарих ажлыг зохион байгуулж, шинэс, гацуур, хус зэрэг 5 төрлийн 320 гаруй мод тарьж суулгав.	100
10	Арга хэмжээ-1.1.10 Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейн зураг төсөв боловсруулах болон цахилгаанаар хангах ажлыг зохион байгуулах	Нийслэлийн төсөв	Батлуулсан зураг төсвийн тоо	-	1	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/253 дугаар захирамжаар төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлж, Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейн зураг төсвийн ажил 160,000,000 (нэг зуун жаран сая)-ын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагаар “Аркусис” ХХК шалгарч зургийг гүйцэтгүүлж батлуулав.	100
11	Арга хэмжээ-1.1.11 Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх	Нийслэлийн төсөв	Шинээр байгуулсан мэдээллийн төвийн тоо	7	1	Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлын хүрээнд жуулчид хамгийн ихээр зорчдог байршлын судалгааг гаргасан. Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр Жуулчны гудамжийг тохижуулах төсөл, арга	

						хэмжээтэй уялдуулан Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр тухайн байршилд байгуулахаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлэн шийдвэрлүүлж, бэлтгэлийг ханган ажиллаж байна.	
1.2. “Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамраарлыг бууруулах чиглэлээр:							
12	Арга хэмжээ-1.2.1 Аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгах зорилгоор өвлийн улиралд иргэд, жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагын тоог нэмэгдүүлэх	Нийслэлийн төсөв	Байгууллагын тоо	69	80	Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “Go Winter - Өвлийн хямдралтай аян”-ыг зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 салбарын 82 аж ахуйн нэгж, байгууллага 100 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 10-50 хувь хүртэл хөнгөлөлттэй үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүллээ.	100
13	Арга хэмжээ-1.2.2 Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	4	4	Монгол Улсын Засгийн газрын “Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2024 оны 191 дүгээр тогтоолын хүрээнд Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Мөсөн замын суудлын авто машины уралдаан”, “Монгол нүүдэлчин өвлийн фестиваль-үндэстэн угсаатан жагсаал”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр”, “Монгол адуучин” нийслэлийн аварга шалгаруулах нээлттэй тэмцээн зэрэг 7 арга хэмжээг зохион байгууллаа.	100
1.3.“Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг дунд, бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллах чиглэлээр:							
14	Арга хэмжээ-1.3.1 Жуулчдад зориулсан төрөлжсөн худалдаа үйлчилгээний гудамж, хэсгийг бий болгох	Улс, орон нутгийн төсөв	Бий болгосон гудамж, хэсгийн тоо	2	1	Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн гудамж, явуулын үйлчилгээг бий болгох, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд худалдаа үйлчилгээний гудамж, хэсэг байгуулах 5 газрын судалгааг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран гаргасан.	70

15	Арга хэмжээ-1.3.2 Аялал жуулчлалын арга хэмжээнүүдийн үеэр худалдаа, үйлчилгээний явуулын үйлчилгээг бий болгож, жижиг дунд, бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллах	-	Жижиг дунд, бизнес эрхлэгчдийн тоо	-	500	Гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан 20 эвент арга хэмжээ, үзэсгэлэнгийн үеэр түр ажлын байр бий болгож 751 жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдааг гаргаж 14,579,681,400 төгрөгийн борлуулт хийсэн. Мөн Унгар Улсын Будапешт хотноо 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатарын соёлын өдрүүд” арга хэмжээний хүрээнд жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 21 аж ахуйн нэгж, иргэн 2130 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож, үзэсгэлэн худалдаа зохион байгуулав.	100
1.4.“Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэд технологийг нэвтрүүлж, контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчилах чиглэлээр:							
16	Арга хэмжээ-1.4.1 Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны материал шинэчлэн хэвлүүлэх	Нийслэлийн төсөв	Сурталчилгаа-ны материалын тоо	19,000	25,000	Нийслэл Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн, арга хэмжээний үеэр ашиглах Улаанбаатар сэтгүүл (Англи, Герман, Япон, Солонгос, Орос, Хятад хэл дээр), Улаанбаатар хотын хөтөч ном (Guide book), жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг (City map) зэрэг 8 төрлийн 27,450 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж Монгол Улсад суугаа гадаад улсуудын Элчин сайдын яамд, консулын газрууд, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, зөвлөгөөн, эвент арга хэмжээнүүдэд тарааж Улаанбаатар хотыг сурталчлан ажиллаж байна.	100
17	Арга хэмжээ-1.4.2 Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчлах	Нийслэлийн төсөв	Эй Ар, Ви Ар (AR, VR) технологиор бүтээсэн сурталчилгаа-ны тоо	-	2	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд мета куэст 3S төрлийн 11 ширхэг Ви Ар (VR) төхөөрөмжийг худалдан авч, 8 арга хэмжээ, 13 үзвэр, үйлчилгээний газар, 6 дурсгалт газар нийт 27 бүтээгдэхүүн үйлчилгээнд VR 360 зураг авалт хийж, Web AR 3D модель контент хийсэн.	100

18	Арга хэмжээ-1.4.3 Жуулчдад зориулсан гар утасны аппликейшн хөгжүүлэх	Нийслэлийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	Гадаад, дотоодын иргэд, жуулчид аялал жуулчлалын байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлэх, төлбөр тооцооны ухаалаг систем, үзвэр үйлчилгээ, байршуулах хэрэгсэл, хоол үйлчилгээ, нийтийн тээвэр болон такси үйлчилгээг нэг дороос худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Visit.ub мобайл аппликейшн" болон www.visitub.com веб цахим системийн UI, UX дизайныг бүтээх, хөгжүүлэх ажлыг "Эрксис монголиа" ХХК, "Эн Эм Эм Эй ХХК, "Премиум капитал трейдэрс" ХХК-аар гүйцэтгүүлж байна.	70
19	Арга хэмжээ-1.4.4 Жуулчдад зориулсан контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчлах	-	Контентын тоо	5	5	"Улаанбаатарын өвлийн наадам", "Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль", "Мөсөн замын суудлын авто машины уралдаан", "Монгол нүүдэлчин өвлийн фестиваль", "Бүргэдийн баяр", "Наурызын баяр", "Монгол адуучин" тэмцээн, "УБ фүүд фестиваль Узбеки улсын хоолны өдөрлөг", Францын соёлын өдрүүд, "Улаанбаатар травэл экспо", Унгар удсын Будапешт хотод зохион байгуулагдсан "Улаанбаатар хотын өдрүүд" арга хэмжээ, "Талын салхи" олон улсын мото фестиваль, "Бурхан багшийн дүйчин өдөр" "Плэйтийм" хөгжмийн наадам, "Дээлтэй монгол" наадам, Улаанбаатар хотын иргэдийн өдөр "Хүрээ цам-Даншиг наадам", Жуулчдад зориулсан "Бэсрэг даншиг наадам" "Солонгосын соёлын өдрүүд", "Улаанбаатар" явган алхалтын фестиваль, "Хийморь" Морьт харвааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, "Аи Ти Эм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн зэрэг 22 арга хэмжээнүүдтэй холбоотой 35 төрлийн видео танилцуулга, контент хийж байгууллагын www.tourism.ub.gov.mn www.visitulaanbaatar.net цахим хуудас болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд байршуулж олон нийтэд сурталчилсан.	100
1.5. "Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр:							
20	Арга хэмжээ-1.5.1 Улаанбаатар хотын аялал жуулчлалын	Нийслэлийн төсөв	Үзэсгэлэн, арга	10	4	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, зорилгоор Соёл,	100

	бүтээгдэхүүнийг улсад сурталчлах олон		хэмжээний тоо		спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, тур оператор компаниудтай хамтран олон улсын 9 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож Улаанбаатар хотыг сурталчилсан. Үүнд: ✓ ХБНГУ-ын Берлин хотноо 2025 оны 03 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “ITB Berlin” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ✓ БНХАУ-ын Засаг Захиргааны онцгой бүс болох Хонгконг хотноо 2025 оны 04 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбооны (WTCF) ээлжит чуулга уулзалт арга хэмжээ, ✓ БНХАУ-ын Бээжин хотноо 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “COTTM-2025” (China Outbound Travel & Tourism Market) олон улсын үзэсгэлэн, ✓ Улаанбаатар хотноо 2025 оны 05 сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатар травэл экспо 2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ✓ БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 06 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “SITF 2025-Seoul International Travel Fair” олон улсын үзэсгэлэн, ✓ БНСУ-ын Бусан хотноо 2025 оны 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Дэлхийн Хотуудын Аялал Жуулчлалын дээд хэмжээний уулзалт”, ✓ Япон улсын Токио хотноо 2025 оны 09 дүгээр сарын 25-29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Tourism Expo Japan -2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ✓ БНСУ-ын Жэжү мужад 2025 оны 11-р сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Жэжү Олле” явган алхалтын фестиваль, ✓ БНХАУ-ын Ханиань мужийн Санья хотноо 2025 оны 11 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Ази, номхон далайн аялал	
--	--	--	------------------	--	---	--

						жуулчлалын холбооноос зохион байгуулсан арга хэмжээнд оролцлоо.	
21	Арга хэмжээ-1.5.2 Найрамдалт харилцаат хотуудад Улаанбаатар хотыг сурталчлах соёл урлаг, аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах	Нийслэлийн төсөв	Арга хэмжээний тоо	1	2	1.Унгар Улсын Будапешт хотноо “Улаанбаатарын соёлын өдрүүд” арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгууллаа.“Улаанбаатар хотын соёлын өдрүүд” арга хэмжээний хүрээнд “Go Mongolia” үндэсний аялал жуулчлалын брэндийг сурталчлах өдөрлөг, “Монгол үндэсний хоолны өдөрлөг”, “Морьт харвааны үзүүлбэр”, “Монгол Унгарын түүхийн жимээр” гэрэл зургийн үзэсгэлэн, баримтат кино, хүндэтгэлийн урлагийн тоглолт болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, гар урчуудын үзэсгэлэн худалдааг зохион байгуулав. “Go Mongolia” үндэсний аялал жуулчлалын брэндийг сурталчлах өдөрлөгт Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Европ зах зээлийн салбар холбооны 8 тур оператор компани оролцож аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, гар урчуудын үзэсгэлэн худалдаанд 9 дүүргийн 21 аж ахуйн нэгж, иргэн 2130 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож, Улаанбаатар театрын уран бүтээлчид үндэсний урлагийн тоглолтоо зохион байгуулж, Монгол үндэсний хоол, ундааг сурталчлан “Улаанбаатар хотын соёлын өдрүүд” арга хэмжээг нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхов. 2.Монгол, Хятад, Орос гурван улсын “Түмэн газрын цайны зам” соёл, аялал жуулчлалын сурталчилгааны арга хэмжээ БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод 2025 оны 8 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, цайны замын холбооны гишүүн 100 гаруй муж, аймаг, хотуудын төлөөллүүд, аялал жуулчлалын бизнес эрхлэгч холбоод оролцов. Монгол Улсаас Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, 8 байгууллага, соёл, урлагийн төлөөлөл оролцож үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа.	100
22	Арга хэмжээ-1.5.3	Нийслэлийн төсөв	Арга хэмжээний	3	4	Найрамдалт харилцаат 4 хотуудын арга хэмжээг Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Үүнд:	100

	Улаанбаатар хотод Найрамдалт харилцаат хотуудын аялал жуулчлал, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах		тоо		1. Монгол, Франц хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд “Франц хотхон” соёл, аялал жуулчлалын арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр Франц хэлээр үйл ажиллагаагаа явуулдаг дипломат байгууллага, боловсрол, соёл, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний 30 гаруй байгууллага үйл ажиллагаагаа танилцуулж, “Франц улсад суралцах, аялах талаар мэдээлэл өгч, соёл, урлагийн тоглолт, хоол үйлчилгээ зэрэг олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Арга хэмжээг гадаад, дотоодын нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхсон. 2. Япон, Монгол хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэх, Монголын залууст Япон улсын түүх, соёлыг таниулах, сурталчлах зорилготой “Japan Festival in Mongolia-2025” арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Япон улсад суралцах, аялах талаар мэдээлэл өгч, Японы уламжлалт соёл, урлагийн тоглолт, хоол үйлчилгээ, аниме, косплей, и спорт зэрэг олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. 3. Монгол, БНСУ хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг тохиолдуулан “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” (Korea Week) арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 06, 07-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Жолланамдо муж, КТО (БНСУ-ын аялал жуулчлалын төрийн өмчит корпорац), KOTRA (БНСУ-ын гадаад худалдаа хөрөнгө оруулалтын агентлаг), KOICA (БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага) зэрэг 84 байгууллага оролцож үйл ажиллагаагаа танилцууллаа. 4. Монгол, Хятад, Орос гурван улсын аялал жуулчлалын сайд нарын нэгдсэн есдүгээр хуралдаан Дархан-Уул аймгийн Дархан хотод 2025 оны 11 дүгээр	
--	---	--	-----	--	--	--

						сарын 07-ны өдөр зохион байгуулагдлаа. Арга хэмжээтэй уялдуулан БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Эрхүү хот, Улаанбаатар хотын аялал жуулчлалын байгууллагуудын уулзалт, арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр “Чингисийн хүрээ” аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа.	
23	Арга хэмжээ-1.5.4 Олон улсын залуучуудын “Аспак” чуулга уулзалтыг хамтран зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100	Ази, Номхон далайн бүсийн "Аспак-2025" чуулга уулзалтад оролцох гадаад улсаас оролцох зочид төлөөлөгчдийг байршуулах зочид буудлын судалгааг зохион байгуулах Ажлын хэсэгт хүргүүлсэн. "Аспак-2025" чуулга уулзалт 2025 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж дэлхийн 70 орчим улсын 5000 орчим төлөөлөгч оролцсон.	100
1.6.Гадаад, дотоод хэвлэл мэдээллийн байгууллагууд, дэлхийд алдартай аялагч нөлөөлөгчдийг урин Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах чиглэлээр:							
24	Арга хэмжээ-1.6.1 Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, жуулчдад зориулсан арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	Нийслэлийн төсөв	Хамтарч ажилласан хэвлэл мэдээллийн байгууллагын тоо	2	7	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, жуулчдад зориулан зохион байгуулсан үзэсгэлэн, эвент арга хэмжээнүүдийн талаар MYONPT, UBS, TV5, Eagle, TB9, C1, SBN, Монгол ТВ зэрэг 10 телевиз, News.mn, Gogo.mn, Zarig.mn, Eguur.mn, Ikom.mn зэрэг 25 сайт, Өдрийн сонин, Өнөөдөр, Монголын мэдээ зэрэг 5 сонин нийт хэвлэл мэдээллийн 42 байгууллагаар 23 удаагийн ярилцлага, нэвтрүүлэг, 50 гаруй мэдээ мэдээллийг түгээж, мөн “Дэлхийн Монголчуудын MGL” радиогийн Дөрвөн зүгийн шуугиан, Өдөр тутмын мэдээ, Пин пост буланд 11 эвент, арга хэмжээний талаар цуврал мэдээ мэдээлэл нийтлүүлж үйл ажиллагаагаа сурталчлан ажилласан.	100
25	Арга хэмжээ-1.6.2 Улаанбаатар хотын аялал жуулчлалыг иргэд олон нийт, жуулчдад түгээн сурталчлах	-	Хандалтын тоо	1,659,489	2,000,000	Байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn , www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд давхардсан тоогоор 1488 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 3,219,009 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан. Тухайлбал: ✓ www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 178 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 10,870,	100

						✓ www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 81 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 41, 564 ✓ https://www.facebook.com/UlaanbaatarTourism цахим хуудсанд 911 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 37,208 хандалтын тоо 3,136,805 ✓ https://www.instagram.com/visit.ulaanbaatar/ цахим хуудсанд 280 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 416, хандалтын тоо 18,247 ✓ https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZziEEnhXfPFA цахим хуудсанд 38 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 517, хандалтын тоо 11,523 байна	
26	Арга хэмжээ-1.6.3 Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг дэлхийд алдартай нөлөөлөгчдөөр (инфлюнсэр) дамжуулан олон улсад сурталчлах	Нийслэлийн төсөв	Сурталчилгаа-ны тоо	-	4	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах зорилгоор "Бүргэдийн баяр-2025" арга хэмжээний үеэр Аяллын тойрог нэвтрүүлэг, "УБ фүүд фестиваль-Узбек улсын хоолны өдөрлөг" арга хэмжээний үеэр сошиал орчинд нөлөө бүхий 2 инфлюнсэрээр, Унгар Улсын Будапешт хотноо 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Улаанбаатарын соёлын өдрүүд" арга хэмжээг Унгар улсын 5 инфлүнсэрээр дамжуулан цахим орчинд контент бэлтгэн 2,250,000 хүнд хүргэсэн.	100
Хоёр.Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг							
2.1.Хөгжлийн бодлого болон захирамжлалын баримт бичгүүдийн хэрэгжилтийн чиглэлээр:							
27	Арга хэмжээ-2.1.1 Улс, нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд санал боловсруулж хүргүүлэх, байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж тогтоосон хугацаанд тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	90-100	90-100	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө, төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Улс, нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж 2025 оны жилийн эцсийн байдлаар Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 95,0 хувь, "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны	100

						хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6 зорилтын 24 арга хэмжээний биелэлт 96,36 хувь, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 2 зорилт, 8 дэд зорилтын 23 арга хэмжээний хэрэгжилт 91,7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тогтоосон хугацаанд тайлагнаж ажилласан.	
28	Арга хэмжээ-2.1.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Засаг даргын зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн холбогдох заалтыг хяналтад бүртгэж, хэрэгжилтийг ханган тогтоосон хугацаанд тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	90-100	90-100	Байгууллагын чиг үүрэгт хамаарах Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 29 заалт, Нийслэлийн Засаг даргын 25 захирамж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн 8 заалтыг байгууллагын хяналтад бүртгэж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт (түүвэр) 97,5 хувь, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 98,8 хувь, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 98,3 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнасан.	100
29	Арга хэмжээ-2.1.3 Засгийн газрын гишүүн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай төрийн зарим чиг үүргийг 2025 онд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, заасан хугацаанд тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	90	90-100	Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нар 2025 онд хамтран ажиллах гэрээ байгуулаагүй болно.	100
30	Арга хэмжээ-2.1.4 Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын үйл	-	Шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	10	12	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хүрээнд бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан зэрэг давхардсан тоогоор 18	100

	ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх					баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд: Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 95,0 хувь, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6 зорилтын 24 арга хэмжээний биелэлт 96,36 хувь, Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 2 зорилт, 8 дэд зорилтын 23 арга хэмжээний хэрэгжилт 91,7 хувь, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт (түүвэр) 97,5 хувь, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 98,8 хувь, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн биелэлт 98,0 хувь, байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн тайлан 95,2 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.	
2.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:							
31	Арга хэмжээ-2.2.1 “Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	Байгууллагын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	95.0	100	1.Нийслэлийн Аялал жуулчлалын газрын албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр баталж, нийт 34 удаагийн сургалтад давхардсан тоогоор 161 албан хаагч, 10 удаагийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, хөтөлбөрт давхардсан тоогоор 37 албан хаагч хамруулж, гадаад улс оронд зохион байгуулагдсан үзэсгэлэн, арга хэмжээнд 16 албан хаагч оролцож туршлага судалсан. 2. “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж, төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: ✓ Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын дагуу 16 албан хаагчид ээлжийн амралтын олговор, давхардсан тоогоор 115 албан хаагчид илүү цаг ажилласан нэмэгдэл хөлс олгож, хүний нөөцийн нэгдсэн	100

						систем https://hrm.csc.gov.mn/ системд албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. ✓ Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг 2 удаа буюу Монгол, Японы эмнэлэгтэй хамтран 10 албан хаагчийг, Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтран 20 албан хаагчийг эрүүл мэндийн эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. ✓ Төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулах саналыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн Ахлах түшмэл-Тэргүүн зэрэг 1, Ахлах түшмэл-Дөтгөөр зэрэг 1, Дэс түшмэл-Гутгаар зэрэг-2, Дэс түшмэл Дөтгөөр зэрэг 2 нийт 6 албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг ахиулах болон шинээр олгуулж, төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг 1 албан хаагч өргөсөн. ✓ Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын 40 хүүхдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. ✓ Албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулан 15 иж бүрэн компьютер, 3 принтер, 18 сандал, 18 ширээ, 20 бичгийн болон хувцасны шкаф, 20 ширхэг бичгийн шүүгээгээр хангаж, нэмэлтээр 4 ширхэг принтер, 5 ширхэг компьютерыг шийдвэрлүүлэн ажиллах нөхцөл, техникээр хангасан.	
32	Арга хэмжээ-2.2.2 Хүний нөөцийн ил тод байдлыг ханган сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/52 дугаар захирамжаар Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газрын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталж Захиргаа, санхүүгийн хэлтэс, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс, Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс гэсэн зохион байгуулалтын 3 нэгжтэй, 20 албан хаагчтай байхаар баталсан. Бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай	100

						холбогдуулан Ахлах нягтлан бодогч, Няравын албан тушаалын сул орон тооны зарыг нийтэд ил тод мэдээлэн сул орон тоог нөхөх ажлыг зохион байгууллаа. Мөн 10 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд цаасан суурьт хэлбэрээр болон цахим системээр хүргүүлэв. Төрийн албан хаагчийн сул орон тооны зарыг нийтэд ил тод мэдээлж, Эвент хариуцсан мэргэжилтэн, Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн, Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн тусгай шалгалтыг зохион байгуулж, 2 албан хаагчийг албан тушаалд томилсон.	
33	Арга хэмжээ-2.2.3 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	1.Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хороотой хамтран “Хайраа хайрлая, Хандлагаа өөрчилъе, Хамтдаа үлгэрлэе” уриан дор зохион байгуулагдсан “Харилцан хүндэтгэе” аянд нийслэлийн Аялал жуулчлалын газрын хамт олон нэгдэж 2 төрлийн баннер, бичлэгийг байгууллагынхаа цахим хуудсаар дамжуулан 6,000 гаруй хүнд хүргэсэн. Мөн жендерийн эрх тэгш байдлыг хангах, албан хаагчдын мэдлэг, мэдээллийг сайжруулах зорилгоор “Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт” сэдэвт сургалтад 2 албан хаагчийг хамруулсан. 2. Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын дагуу 13 албан хаагчид хүүхдээ хичээл, сургуульд нь хүргэж өгөх ажлын цагийн зохицуулалт хийж, мөн нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд болон тэмдэглэлт өдрүүд, амралтын өдрүүдэд ажилласан нийт 115 (давхардсан тоогоор) албан хаагчдад илүү цаг ажилласан нэмэгдэл хөлсийг тооцон олгож, долоо хоногийн нэг өдөр цахимаар ажиллуулж байна.	100
34	Арга хэмжээ-2.2.4 Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	90	100	Байгууллагын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр газрын даргаар батлуулан хэрэгжүүлж байна.батлан хэрэгжүүлж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын	100

	гэгээрүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажиллах					зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 9 албан хаагч хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд тайлагнаж, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн дүгнэлтийг үндэслэн 3 албан хаагчийг албан тушаалд томилсон. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зориилгоор 2 удаагийн сургалтад нийт 7 албан хаагчийг хамруулсан. Авлигатай тэмцэх газраас гаргасан баннер, видео бичлэгийг байгууллагын сайт, facebook цахим хуудсанд байршуулж 2000 гаруй хүнд мэдээлэл хүргэж, Авилгын эсрэг “#Нэгдье#ШҮГЭЛ#АВЛИГЫН-ЭСРЭГ-НЭГДЬЕ” уриалгуудыг амралтын газар, жуулчны бааз, зочид буудал, дэн буудлын группээр дамжуулан 3 төрлийн мэдээллийг дамжуулан хүргэсэн. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага”-ыг цахим хуудсанд байршуулж, Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн буланг сар бүр шинэчлэн ажиллаж байна.	
35	Арга хэмжээ-2.2.5 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	90	90	Байгууллагын Ёс зүйн дэд хорооноос 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Ёс зүйн хороо, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан Ёс зүйн хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах сургалтад 3 албан хаагчийг харуулж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, холбогдох журмыг гарын авлагаар бэлтгэж шинээр томилогдсон албан хаагчдад танилцуулсан.	100

2.3. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:

36	Арга хэмжээ-2.3.1 Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллаж төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнах	Байгууллагын төсөв 878.6	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	Санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж санхүүгийн тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь тайлагнаж, шинээр авлага, өр төлбөр үүсгээгүй, он дамжсан өр, авлага үүсгээгүй бөгөөд нийт батлагдсан төсвийг зардлын ангилал тус бүрээр нь зарцуулсан. Үүнд: ✓ Үндсэн цалин 578,061,759.06 ✓ Нийгмийн даатгалд 68,315,800.75 ✓ Байр ашиглалт 4,201,956 ✓ Хангамж, бараа материалын зардал 15,766,567 ✓ Бусдаар гүйцэтгэгтүүлэх ажил үйлчилгээ 32,041,330	100
37	Арга хэмжээ-2.3.2 Байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх	-	Орлого бүрдүүлэлт	36.0	35.0	"Сити тур" төслөөс 2025 оны төсөвт 35,000,000 (гучин таван сая) төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тусгасан. Сити тур төсөлд ашиглагдаж байгаа автобусанд эвдрэл гарсан, замын хөдөлгөөний ачаалал их, ажиллах хүчний хүрэлцээгүй байдал, улирлын хамаарал зэргээс шалтгаалан төлөвлөсөн орлогыг бүрдүүлэх боломжгүй болсон тул НЗДТГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газартай зөвшилцөн 26,478,560 төгрөгөөр бууруулан 2025 онд төвлөрүүлэх орлогыг 8.521.440 болгож бууруулсан дүгнээр орлого төвлөрүүлээд байна.	100
38	Арга хэмжээ-2.3.3 Байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэлийг ханган ажиллах	-	Хэрэгжилт, хувиар	100	100	Байгууллагын "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-ийн хуралдааныг 2025 оны 04 сарын 17-ны өдөр зохион байгуулж ашиглалт, эдэлгээ дууссан эд хөрөнгийг актлах тухай хэлэлцэн бүртгэлд байгаа ашиглалтын хугацаа дууссан, шаардлага хангахгүй 111,542,391 төгрөгийн 333 ширхэг тавилга, эд хогшил, тоног төхөөрөмжийг актлуулах саналыг хүргүүлж, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2025 оны А/203 дугаар тушаал, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2025 оны А/34 дугаар тушаалаар эргэлтийн бус хөрөнгүүдийг акталж, 40 нэр төрлийн 268 ширхэг бараа материалыг данс бүртгэлээс хасаж, 6 нэр төрлийн 19 ширхэг эргэлтийн бус хөрөнгийг бүртгэж авсан. Мөн Нийслэлийн Өмчийн харилцааны газрын А/292 дугаар тушаалын дагуу эргэлтийн бус хөрөнгийн	100

						дансанд бүртгэлтэй 4 пос машиныг Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газарт балансаас баланст шилжүүлж, данс бүртгэлээс хассан.	
39	Арга хэмжээ-2.3.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн ил тод байдлыг ханган цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийг үнэн зөв тогтоосон хугацаанд байршуулах	-	Хэрэгжилт, хувиар	100	100	Шилэн дансны тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж www.info.shilendans.gov.mn цахим санд байгууллагын жилийн төсөв, гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн тайлан, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд байршуулан тайлагнаж, үндсэн болон нэмэлтээр санхүүжсэн үйл ажиллагааны чиглэлээр нийт 29 төрлийн 319 мэдээллийг цаг хугацаанд нь тайлагнасан. 2025 оны III улиралын байдлаар 93% ийн үнэлгээтэй байна.	100
2.4. Бусад нийтлэг чиг үүргийн чиглэлээр:							
40	Арга хэмжээ-2.4.1 Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар, бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	-	Хэрэгжилт, хувиар	100	100	Нийслэлийн удирдах ажилтнуудын 21 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс байгууллагын чиг үүрэгт хамаарах 75 үүрэг даалгаврын биелэлтийг заалт тус бүрээр бүрэн ханган хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь https://erp.ulaanbaatar.mn/ программын Хяналт шинжилгээ, үнэлгээний дэд системээр болон ERP-ээр тайлагнаж, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хуулийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ, мэдээлэл, судалгааг цаг хугацаанд нь хүргүүлж, нийслэлийн удирдлагуудаас холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн тухай бүр тайлагнан ажилласан.	100
41	Арга хэмжээ-2.4.2 Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс байгууллагын хариуцах индексийн үзүүлэлтийг тогтох, суурь түвшинг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	-	90	Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс Хот орчмын соёл, аялал жуулчлалын түвшин /рекреаци/, Аялал жуулчлал, соёл арга хэмжээнд оруулсан хөрөнгө оруулалт үзүүлэлттэй уялдуулан үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Тухайлбал: ✓ Аялал жуулчлал, соёлын арга хэмжээнд оруулсан хөрөнгө оруулалт үзүүлэлтийн хүрээнд Улаанбаатар хот орчмын түүх соёлын үл хөдлөх дурсгалуудыг аялал жуулчлалын эргэлтэд оруулах ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, “Бэлхийн амны Хүннүгийн	70

						язгууртны цогцолборыг тохижуулах төсөл, арга хэмжээ”, “Арван Долоо Гучин Долоо Энтертайнмент” ХХК-тай хамтран Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгон хөгжүүлэх, зорин очих газрыг нэмэгдүүлэх зорилгоор “Плэйтийм” тогтвортой ногоон хүрээлэн цогцолбор байгуулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлж байна. ✓ Хот орчмын соёл, аялал жуулчлалын түвшин /рекреаци/ үзүүлэлтийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран 20 арга хэмжээг зохион байгуулж гадаад, дотоодын нийт 288,836 хүн үзэж сонирхов.	
42	Арга хэмжээ-2.4.3 Хариуцсан чиг үүргийн хүрээнд шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлэх ажлыг хамтран зохион байгуулах	-	Хэрэгжилт, хувиар	100	100	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын засаглалын төлөв байдлын үнэлгээ-байгууллага дотооддоо үнэлгээ зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/19 дүгээр тушаалаар үнэлгээг зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн үнэлгээний асуулга, асуулт бүртэй нэг бүрчлэн танилцан 120 асуулт бүхий үнэлгээг зохион байгуулж https://survey.moontra.com/ цахим хуудсаар 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр илгээсэн.	100
43	Арга хэмжээ-2.4.4 MNS ISO 9001:2016-чанарын менежментийн тогтолцооны стандартын баталгаажуулалтыг эрх бүхий байгууллагаар хийлгэх	-	Баталгаажуулалт хийлгэсэн баримт бичиг		1	MNS ISO 9001:2015 стандартыг байгууллагын үйл ажиллагаандаа нэвтрүүлж 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр гэрчилгээ авсан. Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2025 оны А/15 дугаар тушаалаар Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэх Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталж, MNS ISO 9001:2015 стандартыг байгууллагын үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	100

						чиглэлээр 2025-2026 онд хэрэгжүүлэх ISO-365 хөтөлбөрийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг ханган ажилласан.	
44	Арга хэмжээ-2.4.5 Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг хамтран зохион байгуулах	-	Хэрэгжилт, хувиар	90	90	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.3.2-т заасан “Хяналт шалгалтын тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний цогц систем /DME/-ийг хөгжүүлж, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн үнэлгээг боловсронгуй болгоно” зорилтын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын хүрээнд бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан зэрэг баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж байна.	90
45	Арга хэмжээ-2.4.6 Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийн боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг хамтран эхлүүлэх	-	Хэрэгжилт, хувиар	90	90	“Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо” нийтийн эрх зүйн этгээдтэй хамтран Монгол Улсад ирсэн жуулчдын статистик тоон мэдээллийн МУ-ын хилээр нэвтэрсэн гадаадын иргэдийн тоонд үндэслэн өдөр, сар, жилээр, улсаар нь ангилан гаргаж олон нийтэд хүргэн ажиллаж байна.	90
46	Арга хэмжээ-2.4.7 Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсуулж батлуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах	-	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт	-	90	“Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй” сургалтад 2 албан хаагчийг хамруулж, зөвлөмж чиглэлийн дагуу “Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, батлуулахаар саналын хуудсаар санал авч байна.	70
Гурав: Төрийн үйлчилгээ							
3.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх чиглэлээр:							
47	Арга хэмжээ-3.1.1 “Онлайн бизнес төв” нэгдсэн мэдээллийн системийн “Үйлчилгээ	-	Шийдвэрлэлтийн хувь	80	100	Нийслэлийн https://www.ulaanbaatar.mn/ портал системийн “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл” цэсэд 247 иргэн, хуулийн этгээд зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны	100

	эрхлэх бүртгэл” цэсэд аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдээс зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр бүртгэлийг тухай бүр хянан шийдвэрлэх					баазын үйлчилгээ эрхлэхээр бүртгүүлж, зөвшөөрсөн 135, хариуцсан дүүрэгт шилжүүлсэн 36, судлагдаж байгаа 8, буцаагдсан 50, татгалзсан 18 төлөвтэй байна.	
48	Арга хэмжээ-3.1.2 Албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх	-	Шийдвэрлэлт ийн хувиар	99	100	Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хариутай 84 албан бичиг, хариугүй 266 албан бичиг нийт 350 албан бичгийг бүртгэж, 383 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу боловсруулан явуулсан. Ирүүлсэн 350 албан бичгээс 345 албан бичгийг эцэслэн шийдвэрлэж, 5 албан бичиг судалж байгаа төлөвтэй. Албан бичгийн шийдвэрлэлт 98.52 хувийн үзүүлэлттэй байна.	100
49	Арга хэмжээ-3.1.3 “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100	Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудсыг захиалан авч тайлант хугацаанд “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 106 тушаал, 383 явуулсан бичиг албан бичгийг хос бичгээр хөтлөн явуулсан.	100
50	Арга хэмжээ-3.1.4 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай хуулийн хугацаанд шийдвэрлэх	-	Шийдвэрлэлт -ийн хугацаагаар	5 хоног	5 хоног	Нийслэлийн Аялал жуулчлалын газарт нийт 27 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100% эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Нийт өргөдөл, гомдлоос албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол болон саналын шинжтэй өргөдөл ирээгүй бөгөөд шийдвэрлэлтийн явцад хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол	100

						байхгүй. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 05 хоног 11 цаг 03 минут байна. Ирсэн өргөдөл гомдлын талаар мэдээллийг улирал тутамд гаргаж Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд илгээн, байгууллагын https://tourism.ub.gov.mn/ цахим хуудсанд байршуулсан.	
51	Арга хэмжээ-3.1.5 “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2024 оны архивын материалыг хүлээн авах, архивын баримтын нэгдсэн данс бүртгэл хөтлөх	-	Хадгаламжийн нэгжийн тоо	160	160	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2024 онд үүссэн хадгаламжийн нэгжүүдийг бүрэн бүрдэлтэйгээр хүлээн авч Байнга хадгалах-81, Түр хадгалах-84, 70 жил хадгалах-3 нийт 168 баримтыг ач холбогдлын дарааллаар байгууллагын архивын санд байршуулсан.	100
52	Арга хэмжээ-3.1.6 Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа болон эвент арга хэмжээний судалгааг гадаад, дотоодын иргэдээс авч, түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	-	Судалгаанд хамрагдсан хүний тоо	1900	2000	Жуулчдад зориулан зохион байгуулсан 10 арга хэмжээнүүдийн үеэр аялал жуулчлалын хүний нөөцийн судалгаа болон иргэд жуулчид, аж ахуй нэгжээс сэтгэл ханамж, эдийн засгийн үр өгөөжийн судалгааг 2550 гаруй хүнээс авсан.	100
53	Арга хэмжээ-3.1.7 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байнга ил тод байлгах мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хууль тогтоомжоор хүлээсэн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, тайлан холбогдох цаг үеийн	-	Байршуулсан мэдээ, мэдээллийн тоо	2832	3000	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллүүдийн хүрээнд байгууллагын зорилго зорилт, үндсэн чиг үүрэг, бүтэц зохион байгуулалт, албан хаагчдын мэдээлэл, төрийн үйлчилгээ болон хүний нөөц, санхүүгийн ил тод байдал, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны тайлан, мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудас болон https://frontoffice-dev.shilen.gov.mn/auth/signin сайтад улирал бүр байршуулж, 93.0 хувийн үзүүлэлттэй байна.	100

мэдээ, мэдээллийг нээлтэй байршуулах					Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, арга хэмжээнүүдийг олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn www.visitulaanbaatar.net болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд 1488 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 3,219,009 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэсэн.	
Нийт дундаж хувь					95,2%	

ТАНИЛЦСАН:
ДАРГА




Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



Д.ГАНБОЛД

ХЭРЭГЖИЛТ НЭГТГЭСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН



О.НЯМБАТ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
СУРГАЛТ, СУДАЛГАА, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН



Ч.ЭНХ-ОТГОН